Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын
02/118 дугаар албан бичгийн хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга	
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороог нийт албан хаагчдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн санал хураалт, олонхын саналыг үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн нарийн бичгийн даргын А/355 дугаар тушаалаар баталсан.	
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар	
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/355 дугаар тушаалаар байгуулагдсан Ёс зүйн дэд хороо дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүнтэйгээр томилогдон ажиллаж байна. Шинээр томилогдсон гишүүд тайлант хугацаанд нийт 11 зөрчил, гомдлыг шалган шийдвэрлэсэн бөгөөд ирсэн гомдол, хяналт шалгах явцад гарсан зөрчилд үнэлэлт дүгнэлт хийж, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал.	
Байгаль орчин, уур амьсгалын салбарын хэмжээнд Ёс зүйн дэд хороодыг байгуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулахад анхаарч шинээр томилогдсон удирдлага, мэргэжилтнүүдэд зөвлөмж өгч ажиллаж байна.	
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	
БОУАӨЯ-ны харъяа байгууллагуудад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Ёс зүйн дэд хороо байгуулах чиглэл, зөвлөмж өгсөн бөгөөд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчын ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрмийн дагуу ажиллаж, шинэчилсэн ёс зүйн дэд хороо 1 удаа хуралдаж, дарга, нарийн бичгийн даргыг сонгосон.	
Гарсан үр дүн, ололт амжилт.	Бэрхшээл.
Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох журам, дүрмийг мөрдөн ажиллаж, ирсэн гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд хянан шалгаж, үнэлэлт дүгнэлт өгсөн нь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бодитой үр дүн үзүүлсэн. Албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад зарим гомдол, мэдээлэл тодорхой бус, нотлох баримт дутмаг ирсэн нь шалган шийдвэрлэх хугацаа сунжрах нөхцөл бүрдүүлсэн. Мөн албан хаагчдын ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаарх ойлголт жигд бус, зарим тохиолдолд ёс зүйн зөрчил гаргасан үйлдлээ зөрчил гэж ухамсарлахгүй байх байдал ажиглагдсан. Үүнээс шалтгаалан урьдчилан сэргийлэх,

төлөвлөсөн нь ёс зүйн зөрчил гарах эрсдэлийг бууруулахад эерэг нөлөө үзүүлсэн. Мөн шинээр байгуулагдсан Ёс зүйн дэд хороо богино хугацаанд үйл ажиллагаагаа жигдрүүлж, дотоод зохион байгуулалтаа ханган ажилласан нь цаашдын тогтвортой ажиллагааны суурь болсон.	соён гэгээрүүлэх ажлыг илүү системтэй, тогтмол зохион байгуулах шаардлага үүссэн.